



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 05 сарын 02 өдөр

Дугаар 170

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн “Улаангомын дулааны хоёрдугаар станц” төрийн өмчит хувьцаат компанийн 2021 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар 611.5 (зургаан зуун арван нэгэн сая таван зуун мянган төгрөг) сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны А-1/66 дугаартай албан даалгаврын биелэлтээр 87.2 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэсүгэй.

2.“Улаангомын дулааны хоёрдугаар станц” төрийн өмчит хувьцаат компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

3.“Улаангомын дулааны хоёрдугаар станц” төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирал (Э.Баатарсан)-д дотоод хяналтыг сайжруулж дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай:

3.1.Шалгалтын тайланд дурдсан зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллах;

3.2.Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний үндэслэлийг сайжруулах, үзүүлэлт бүрээр ханган биелүүлэх, төлөвлөгөөнд тусгагдаагүй зардлыг санхүүжүүлэхгүй, хөрөнгө худалдан авахгүй байх;

3.3.Компанийн дулаан дамжуулах төвийн байгууламжийн зориулалттай, ДДТ-6, ДДТ-8, ДДТ-11, ДДТ-12, ДДТ-13-ын эзэмшлийн газрын хил заагийг шинэчлэн тогтоох, баталгаажуулах, үнэлж санхүүгийн тайланд бүртгэх ажлыг зохион байгуулах;

3.4.2015 оноос хойш үүссэн хуримтлагдсан авлагуудыг хууль, шүүхийн байгууллагад шилжүүлэн шийдвэрлүүлэх, цаашид найдваргүй авлагын нөөц байгуулах асуудлыг судлан шийдвэрлэх;

3.5.Иргэн, аж ахуйн нэгж байгууллагатай байгуулсан гэрээний эрх зүйн үндэслэл, гэрээний зүйл заалтыг иргэний хууль тогтоомжтой нийцүүлэх, гэрээг дүгнэж актаар баталгаажуулж байх;

132034992
11-r huraldaan.docx

3.6.Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй бараа, ажил, үйлчилгээ худалдан авахгүй байх, үйл ажиллагаандаа “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”, Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг мөрдөн ажиллах;

3.7.Тогтоолын биелэлтийг 2023 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.


4.Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах талаар бодиттой, үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлэх, санхүүгийн сахилга батыг хэвшүүлэн ажиллах.

5.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

 Ц.ТҮВШИНЗАЯА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 05 дугаар сарын 02 -ны өдрийн
170 дугаар тогтоолын хавсралт

“Улаангомын дулааны хоёрдугаар станц” төрийн өмчит компанид хийсэн
шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах
арга хэмжээний жагсаалт

Д/д	Зөрчлийн утга	Мөнгөн дүн (сая.төг)	Зөрчил дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн төлөвлөгөөнд тусгагдаагүй зардал санхүүжүүлсэн.	183.0	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 76.1.9, Гүйцэтгэх захиралтай байгуулсан Контрактын 3.2 дах заалтыг хэрэгжүүлэн ажиллах.
2	Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй хөрөнгө худалдан авсан.	5.2	
3	Дулаан дамжуулах төвийн байгууламжийн зориулалттай, ДДТ-6, ДДТ-8, ДДТ-11, ДДТ-12, ДДТ-13-ын газруудын эзэмших/ашиглах эрхийг баталгаажуулаагүй.	5 ш газар	Засгийн газрын 2020 оны Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай 10 дугаар тогтоолын 4 дэх хэсгийг үндэслэн Сангийн сайдын баталсан аргачлалын дагуу үнэлж бүртгэх.
4	Худалдан авах ажиллагаанд техникийн тодорхойлолтыг хууль журмын дагуу боловсруулаагүй. Зарим худалдан авалтыг цахим системд байршуулаагүй,	237.7	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, журмуудын хэрэгжилтийг ханган ажиллах.
5	2020 онд Эвлэрлийн гэрээ байгуулснаас шүүхийн шийдвэрийн дагуу үүссэн өр төлбөрийг барагдуулж компанийн хөрөнгөөс үргүй зардал гаргасан.	115.8	Компанийн тухай хуулийн 76.1.17, 17дах хэсэгт заасныг хэрэгжүүлэн ажиллах.
6	Гэрээний эрх зүйн үндэслэл муу, дугаарлалт байхгүй, гэрээний зорилго, хугацаа тусгагдаагүй.	37 ш гэрээ	Иргэний хуульд нийцүүлэх, гэрээг актаар баталгаажуулах.
7	Хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулаагүй.	69.8	Хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шийдвэрлүүлэх.
	Нийт дүн	611.5 (зургаан зуун арван нэгэн сая таван зуун мянга)	